



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 11 сарын 06 өдөр

Дугаар 1/4

Бат-Өлзий сум

Үндсэн хөрөнгийн тооллогын
ажлын хэсэг байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 71 дүгээр зүйл, 72 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгийн 2024 оны сүүлийн хагас жилийн тооллого хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Пүрэвсүрэн (Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч)

Гишүүд: С.Төмөр (Багийн Засаг дарга)

Г.Хорол-Эрдэнэ (иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
мэргэжилтэн)

Ц.Маргад-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын
нярав)

Д.Баяржаргал (үйлчлэгч)

2.Үндсэн хөрөнгийн тооллогыг 2024 оны сүүлийн хагас жилийн тооллогыг 2024 оны 11 дүгээр сарын 06-аас 2024 оны 11 дүгээр сарын 13-ны дотор үнэн зөв, бодитой зохион байгуулж, дүн мэдээг нэгтгэн Засаг даргын Тамгын газрын даргад танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Пүрэвсүрэн)-д даалгасугай.



ДАРГА

Н.БАТ-ЭРДЭНЭ